



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/373

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймаг дахь “Шинэ Ховд баруун бүсийн хөгжлийн корпораци” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт нийлүүлэгдэх 182 га-гийн услалтын системийн 4,3 км урт хоолойны тоног төхөөрөмжийг тээвэрлэн авч ирэх зардалд 33,800,000 төгрөгийг зарцуулсугай.

2. Тээвэрлэлтийн зардалд 33,800,000 төгрөг (гучин гурван сая найман зуун мянга)-ийн санхүүжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 сарын 04-ний 5/07 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын “Хөшөөт хөгжил сан”-ийн 5.2 “Шинэ Ховд-Хөдөө аж ахуй агропарк” төсөл арга хэмжээнээс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1822